

ДОТООДЫН ГУРИЛ, ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭ

☎ (976)-7013 7012

✉ contact@mirim.mn

📍 Pro One building, 15th floor, # 1502, Sukhbaatar district,
11th khoroo, Ulaanbaatar-14181, Mongolia

Strategic. Rational. Productive

MIRIM
INNOVATION & CONSULTANT

Marketing
Innovation
Research
Institute of
Mongolia

© 2020 Mirim Consultant LLC.


Энэхүү тойм судалгааны зорилго нь газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэлийн хэмжээ, хэрэглээг тоймлон хүргэж, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Уг судалгааг албан ёсны эх сурвалжуудын (ҮСХ, ГЕГ, ХХААХҮЯ) гаргадаг хоёрдогч статистик тоон мэдээллээс гадна Үндэсний статистикийн Хорооноос жил бүр эрхлэн гаргадаг Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2010-2019 оны анхдагч тоон мэдээлэл дээр үндэслэн боловсруулав.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа нь жил бүр хүн амын амжиргааны түвшин, ядуурал, өрхийн орлого, зарлага болон бусад хүчин зүйлсийг тооцоход зориулсан Монгол улсын хэмжээний түүвэр судалгаа юм.

Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг сүүлийн 10 жилээр тоймлон харвал 2010-2014 он хүртэл тасралтгүй өсч түүнээс хойш өсөлт, бууралттай жилүүд үргэлжилсэн байна. Жишээ нь 2016 онд 729,003 сая төгрөгт хүрч байсан бол 2017 онд 502,439 сая төгрөгт хүрсэн нь өмнөх жилийн дүнгээс 31.8 хувиар буурсан үзүүлэлттэй байв. Харин 2018, 2019 онд хамгийн өндөр түвшинд хүрчээ.

График 1. Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ, сая.төгрөг, 2010-2019



Эх сурвалж: УСХ

2014 онд газар тариалан эрхэлдэг өрхийн тоо 20,459 байсан бол 2015 оноос эхлэн буурсан үзүүлэлтэй байна. Харин аж ахуйн нэгж байгууллагын тоо 2014-2017 он хүртэл өсөөд, 2018 оноос буцаад буурчээ. Газар тариалангийн салбарт өрхийн аж ахуй эрхлэгчийн тоо буурч байгаа шалтгаан нь төр засгийн зүгээс дэмжлэг бага, ургацын хэмжээ хангалтгүй, тухайн салбарт аж ахуй нэгжүүд нэмэгдэж байгаатай холбоотой байж болох юм.


Хүснэгт 1. Газар тариалан эрхлэгч ӨРХ, БАЙГУУЛЛАГА, мянга, 2014-2019

ОН	ӨРХ	АЖ АХУЙ НЭГЖ
2014	20,459	1,352
2015	18,440	1,395
2016	17,145	1,414
2017	15,985	1,447
2018	15,862	1,422
2019	14,728	1,401

Эх сурвалж: УСХ

Улаанбуудай тариалалт, хураалтын хэмжээг сүүлийн 10 жилээр тоймлон харвал тариалсан талбайн хэмжээ харьцангуй тогтвортой байгаа бол хураасан ургацын хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, 2014, 2016 онд хамгийн их ургац авч байсан ч 2015, 2017 онд өмнөх жилийн дүнгээс 42-49 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь тухайн жилийн цаг агаарын нөхцөл байдал, ургацын гарцаас шалтгаалдаг.

График 2. Улаанбуудайн тариалсан талбай болон хураасан ургацын хэмжээ, тонн 2010-2020 он



Эх сурвалж: ХХААХҮЯ

УЛААНБУУДАЙ ТАРИАЛАЛТ, УРГАЦ ХУРААЛТЫН ХЭМЖЭЭ


Аж ахуй нэгжүүд улаанбуудайн ургац хураалтын 90 гаруй хувийг нийлүүлж байна. Тухайлбал, 2014 онд ургац хураалтын **92.4 хувийг аж ахуй нэгж**, 7.6 хувийг өрхийн аж ахуй эрхлэгчид нийлүүлж байсан бол 2019 онд **94.1 хувийг аж ахуй нэгж**, 5.9 хувийг аж ахуй эрхлэгчид нийлүүлжээ. 2019 онд **14,428** мян.тонн улаанбуудай импортоор оруулж ирсэн байна.

График 3. Өрхийн улаанбуудай тариалсан талбай болон хураасан ургацын хэмжээ, тонн, (2014-2019)



Эх сурвалж: ҮСХ


График 4. Аж ахуйн нэгжийн улаанбуудай тариалсан талбай ба хураасан ургацын хэмжээ, тонн, (2014-2019)



Эх сурвалж: ҮСХ

Монгол улс сүүлийн 10 жилд дунджаар 188 мян.тонн гурил үйлдвэрлэжээ. Жишсэн дундаж нэг хүнд өргөн хэрэглээний гурил 36.5 кг, гурилан бүтээгдэхүүнд 65.7 кг буюу гурилд шилжүүлэн тооцвол 49.2 кг, нийт жилийн хэрэгцээнд 85.7 кг гурил шаардлагатай байна. 2020 онд жишсэн хүн амын тоог 2649,9 мянга болно гэж тооцоход Монгол Улсын нийт хүн амын хэрэгцээнд 227 мян.тн гурил буюу 302 мян.тн улаанбуудай шаардлагатай байгааг харуулж байна. (1 кг улаанбуудай = 0.75 кг гурил)

График 5. Гурил үйлдвэрлэлийн хэмжээ, мян.тонн, 2010-2019



Эх сурвалж: ҮСХ

Хүснэгт 2. Улаанбуудайн импортын хэмжээ, мян.тонн

он	Хэмжээ, мян.тонн
2010	66.1
2011	7.4
2012	4.1
2013	0.1
2014	34.2
2015	21.1
2016	158.5
2017	13.62
2018	232,000
2019	14,429

Эх сурвалж: ҮСХ

Гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ жил ирэх тусам ихэвчлэн өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь хүн амын өсөлт, хэрэглэгчийн хэрэглээний зан үйл, эдийн засгийн өсөлт бууралттай холбоотой. Жишээ нь, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2019 оны дүнгээр авч үзвэл 27.7 мян.тн талх, 21.8 мян.тн нарийн боов, 8.8 мян.тн гоймон үйлдвэрлэжээ.


Хүснэгт 3. Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, мян.тонн

Он	Талх	Нарийн боов	Гоймон
2010	19,388	11,610	2,056
2011	21,184	11,419	2,232
2012	22,498	12,098	3,192
2013	21,690	16,594	1,512
2014	25,802	16,739	2,731
2015	23,977	16,344	2,028
2016	22,283	15,994	4,051
2017	23,830	17,749	6,999
2018	27,436	19,462	7,227
2019	27,799	21,856	8,843

ГУРИЛ, ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САРЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ


Статистикийн үндэсний хорооны жил бүр гаргадаг 2019 оны “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны үр дүнгээс харахад нэг хүн **сард дунджаар 9.5 кг гурил, гурилан бүтээгдэхүүн** хэрэглэж байна. Суурьшлаас хамаараад гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэглээ харилцан адилгүй байна. Жишээ нь 2019 онд нэг хүн сард хөдөө орон нутагт 10.5 кг, хотод 8.9 кг гурил, гурилан бүтээгдэхүүн хэрэглэж байна.

График 6. Гурил, гурилан бүтээгдэхүүний сарын дундаж хэрэглээ, /кг/



Эх сурвалж: ҮСХ, ӨНЭЗС 2013-2019

График 7. Гурил, гурилан бүтээгдэхүүний сарын дундаж хэрэглээ, хот, хөдөөгөөр, /кг/



Эх сурвалж: ҮСХ, ӨНЭЗС 2013-2019

Танд баярлалаа...

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
11-р хороо, 7-р хороолол, ПроВан оффис, 15 давхар 1502 тоот

Утас: (976) 7013-7012

Вэб сайт: www.mirim.mn

Имэйл хаяг: contact@mirim.mn